

ДОРНЫН ӨРӨВТАС *Ciconia boyciana* 17 ЖИЛИЙН ДАРАА ДАХИН ТЭМДЭГЛЭГДЛЭЭ

Алтанчимэгийн Маналжав

Nomadic Journeys Ltd, 7/3 Olympic Street Tseltmeg Center #504 Sukhbaatar District Ulaanbaatar 14240 Mongolia

харилцах хаяг: manaljav.a@gmail.com

хураангуй. 2015 оны 8 сарын 31 өдөр Төв аймгийн Баяндэлгэр сумын Гүн-Галуутайн орон нутгийн тусгай хамгаалалттай газар орших Цэнгийн бүрдэд нэг бодгаль Дорнын өрөвтасгай *Ciconia boyciana* таарсан бөгөөд фото зургийг нь авч баримтжуулав. Энэ шувуунд зүүсэн ямар нэгэн тэмдэг, бөгж, дамжуулагч зэрэг байгаагүй нь байгаль дээр бойжсон шувуу байх боломжтой гэдгийг харуулж байна.

түлхүүр үг: ховор шувуу, Гүн галуутай

abstract. We observed and photographed one individual Oriental White-stork *Ciconia boyciana* at the Tsengiin Burd of Gun Galuutai, Bayandelger soum, Khentii aimag. The bird was not ringed suggesting that this bird could be from a non-captive population.

keywords: rare record, Gun Galuutai

Тоодог 2:46-47, 2016

Дорнын өрөвтас *Ciconia boyciana* нь олон улсын хэмжээнд устах аюулд өртөөд байгаа нэн ховор зүйл бөгөөд дэлхийн хэмжээнд 1000-2500 орчим бодгаль үлдсэн байна (BirdLife International 2016). Монгол улсын 1997 онд гарсан улаан номонд “Ховор” гэсэн ангилалд байсан боловч 2014 онд шинэчлэгдэн гарсан Улаан номонд ороогүй (Шийрэвдамба, ред. 2014). Түүнчлэн Монгол орны шувууны Улаан дансанд бүс нутгийн хэмжээнд тоо толгой болон ховордлын зэргийг үнэлэх боломжгүй гэсэн байна (Gombobaatar *et al*, 2011). Харин энэ шувууг Ан агнуурын тухай хуулиар агнахыг хориглосон байдаг.

Дорны өрөвтас нь зөвхөн Зүүн Азид тохиолдох бөгөөд ОХУ-ын Алс Дорнодын Амар мөрний болон Усуурын ай савын хязгаар нутагт голлон үүрлэж өндөглөдөг. Мөн цөөн тооны шувууд Хятадын Хейлонжанг мужын Вуюерхе голын адагт үүрлэдэг мэдээ бий (Zou *et al*, 2007). Энэ зүйл Хятадын зүүн өмнөд хэсгээр буюу Шар мөрний адаг, Поянг нуур, Хонг Конг, Тайван хүрч өвөлждөг (BirdLife International 2016).

Энэ зүйл шувуу колоноор үүрлэдэг бөгөөд үүрээ голдуу ус, намагтай газрын ойролцоо 3.4-14 метрийн өндөр мод эсвэл өндөр хүчдлийн шон дээр засдаг. Идэш тэжээл нь загас, хавч хэлбэртэн, усны жижиг амьтадаар хооллоно.

Дорнын өрөвтас нь 2-6 өндөг гаргах бөгөөд өндгөө дарж эхэлснээс хойш ойролцоогоор 30 хоногийн дараа ангаахай гарна. Ангаахай нь 40 орчим хоногийн дараа үүрээ орхин нисдэг ба 3-4 жилийн дараа үржилд ороход бэлэн болдог байна. Сүүлийн жилүүдэд амьдрах орчны доройтол, идэш тэжээлийн хомсдол, ус намгархаг газруудын хуурайшилт, бохирдол, усан далангийн нөлөө зэргээс болоод тоо толгой нь тогтмол буурч байгаа (BirdLife International 2016).



Зураг 1. Цэнгийн бүрдэд тааралдсан Дорнын өрөвтас (Зургийг А.Маналжав)

Дорнын өрөвтас нь Япон болон Солонгосын хойгт 1970-аад оны үед байгаль дээр устаж үгүй болсон байна. Япон улсад 300 орчим жилийн өмнөөс дорнын өрөвтас тэмдэглэгдсэн мэдээ байдаг бөгөөд 1800 –гаад оны үеэс агнуур болон амьдрах орчны доройтол зэрэг хүчин зүйлсээс болж тоо толгой нь тогтмол буурсаар иржээ. Сүүлд 1940-өөд оны үед дайны бэлтгэлд зориулан маш их хэмжээны мод бэлтгэсэн нь тухайн зүйл шувууны тоо толгойг асар хурдацтай буурахад хүргэжээ (Sakamoto 1966). Тоёоока хотод 1960-аад оны сүүл үед маш цөөхөн буюу 20 дорнын өрөвтас үлдсэн байсан боловч цөөрсөөр 1971 онд сүүлчийн ганц өрөвтасыг барьж тус хотын үржүүлгийн газар аваачсан байна. Энэ өрөвтас 1986 оны 2 сарын 28-нд үхсэнээр японы зэрлэг байгаль дээр бойжсон дорнын өрөвтасын сүүлч үүгээр дууссан байна (Murata *et al*, 1993). Сүүлийн жилүүдэд сэргээн нутагшуулах ажлууд эрчимтэй хэрэгжиж, тоо толгойг нь нэмэгдүүлэх арга хэмжээ авч байна. 2004 оны байдлаар Японы сэргээн нутагшуулах станцад 550 гаруй шувуутай болсон ажээ. Мөн өнөөг хүртэл 200 орчим шувуудыг байгаль дээр суллаж тавиад байна. (Ogawa 2001, Naito and Ikeda 2007).

Дорнын өрөвтас Монгол оронд маш ховор тохиолдох ба Улз, Хэрлэн, Халх голын адагт дандаа нэг нэгээрээ бодгаль тааралдаж байжээ (Фомин ба Болд 1991, Gombobaatar *et al* 2011).

Би 2015 оны 8 сарын 31 өдөр шувуу ажиглах аялалаар Лансе Дегнан (Lance Degnan British Birds Rarities Committee) Ник Ваитхаус (Nick Whitehouse Doncaster and District Ornithological Society) нарын хамт Төв аймгийн Баяндэлгэр сумын Гүн-Галуутайн орон нутгийн тусгай хамгаалалттай газар орших Цэнгийн бүрдэд явж байхдаа нэг бодгаль Дорнын өрөвтастай (*Ciconia boyciana*) таарсан бөгөөд фото зургийг нь авч баримтжуулсан (Зураг 1). Энэхүү ажиглалт нь энэ зүйл шувууны Монгол оронд ажиглагдаж буй 4 дэх удаагийн тохиолдол юм. Хамгийн сүүлд 1998 онд ШУА-ын шувуу судлаач Н.Цэвээнмядаг Дорнод Монголын Дархан цаазат газарт багтах Улз голын савд бүртгэсэнээс даруй 17 жилийн дараа энэ ховор шувуу бидэнд дахин бүртгэгдсэнд туйлын баяртай байна. Энэ шувууг байгаль дээр бойжсон эсвэл сэргээн нутагшуулах ажлын үр

дүнд бойжсон шувуу гэдгийг хэлэх боломжгүй. Магадгүй энэ шувуунд зүүсэн ямар нэгэн тэмдэг, бөгж, дамжуулагч зэрэг байгаагүй нь байгаль дээр бойжсон шувуу байх боломжтой гэдгийг харуулж байна.

Ашигласан хэвлэл

- BirdLife International. 2016. Species factsheet: *Ciconia boyciana*. Downloaded from <http://www.birdlife.org> on 10/03/2016.
- Gombobaatar, S., and Monks, E.M. (compilers), Seidler, R., Sumiya, D., Tsevenmyadag, N., Bayarkhuu, S., Baillie, J. E. M., Boldbaatar, Sh., Uuganbayar, Ch. (editors). 2011. Regional Red List Series Vol.7. Birds. Zoological Society of London, National University of Mongolia and Mongolian Ornithological Society.
- Murata, K., T. Hasegawa, K. Matsushima. 1993. The cause of death of Eastern white storks (*Ciconia ciconia boyciana*) in captivity. J. Jpn Assoc. of Zool. Gardens Aquariums 34:23–27
- Naito, K., and H. Ikeda. 2007. Habitat restoration for the reintroduction of oriental white storks. Global Environmental Research 11:217.
- Ogawa, H. 2001. International Studbook for the Oriental White Stork *Ciconia boyciana*. Tama Zoological Society, Tokyo.
- Sakamoto, M. 1966. Kohnotori: Japanese Stork, *Ciconia ciconia boyciana* (Swinhoe). Kobe Newspaper Press, Kobe (in Japanese with English summary)
- Zou, H., Q. Wu, J. Zhu. 2007. Primary report on conserving Oriental White Stork in Linnian wetland, Heilongjiang. *China Crane News* 11(2):35.
- Фомин, В. Е., А. Болд. 1991. Каталог птиц Монгольской Народной Республики. Наука, Москва.
- Шийрэвдамба, Ц. (ep. ред.). 2014. Монгол улсын улаан ном. Байгаль орчин, ногоон хөгжлийн яам. Улаанбаатар, III хэвлэл. хуудас 348.